



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/102

Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсэг, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын "Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2022 оны 448 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын XV.2.2 Эрүүл мэндийн салбарын их засварын ажлын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлтийг хангаж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад даалгасугай.

САЙД  С. ЧИНЗОРИГ



141223471

Эрүүл мэндийн сайдын 2023 оны  
03 дүгээр сарын 24-ны өдрийн  
1/102 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ  
ИХ ЗАСВАРЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Хуулийн дугаар	Төслийн нэр, хүчин чадал	Хугацаа		Санхүүжилт /сая төгрөг/
		Эхлэх	Дуусах	
XV.2.2	Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/			457.2
XV.2.2.1	ХӨСҮТ-ийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ /Хоол үйлдвэрлэлийн тасаг доторх/ Багц-5	2021	2023	30.59
XV.2.2.2	ХӨСҮТ-ийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ /Хоол үйлдвэрлэлийн тасаг дээврийн засвар/ Багц-4	2021	2023	9.79
XV.2.2.3	ХӨСҮТ-ийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ /Шинэ болон дахин сэргэж буй халдварын тасаг дээврийн засвар/	2021	2023	11.59
XV.2.2.4	ХӨСҮТ-ийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ /Гэдэсний халдварын тасаг дээврийн засвар/	2021	2023	19.73
XV.2.2.5	ХӨСҮТ-ийн их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ /Сүрьеэгийн тасаг дээврийн засвар/	2021	2023	13.43
XV.2.2.6	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн дээвэр, болон түлэнхийн тасгийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ Багц-1	2021	2023	119.00
XV.2.2.7	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн дээвэр, болон түлэнхийн тасгийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ Багц-2	2021	2023	45.95
XV.2.2.8	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Амбулаторийн тасгийн хүлээлгийн танхимын засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2021	2023	17.89
XV.2.2.9	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2021	2023	42.97
XV.2.2.10	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Хэнтий, Өмнөдэлгэр сум Гурван баян тосгон/	2021	2023	46.78
XV.2.2.11	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2021	2023	99.45